

2008.02.28

Дугаар 21

“НИКИ” ХХК-д брокер, дилерийн үйл
ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл
олгох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.3, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 6.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 34.1.4 дэх заалт болон “НИКИ” ХХК-иас ирүүлсэн хүсэлтийг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ НЬ:

1. “НИКИ” ХХК-д үнэт цаасны зах зээлд брокер, дилерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 3 жилийн хугацаагаар олгосугай.

2. “НИК” ХК-ийн 1997, 1998 онуудын ногдол ашгийн тараагдаагүй үлдэгдэл болох 58,3 сая төгрөгийг тооцоо нийлж, харилцагчдын дансанд энэ оны эхний хагас жилд багтаан шилжүүлэхийг “НИК” ХК /С.Сүхбаатар/, “ҮЦТТТХТ” ХХК /Т.Гандулам/, “НИКИ” ХХК /Ө.Түвшинжаргал/-д тус тус үүрэг болгосугай.

3. Хөрөнгө оруулагчид, харилцагчдын эрх ашгийг хамгаалан, хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ биелүүлэн ажиллахыг “НИКИ” ХХК /Ө.Түвшинжаргал/-д үүрэг болгосугай.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж, нийтэд сурталчлан ажиллахыг Үнэт цаасны газар /Э.Ганбат/-т даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН

Хуулбар үнэн:
АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА

О.ГАНБАТ